

“ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГУУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ЭКОСИСТЕМИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ” (SPACES)

ГАРААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол орны байгалийн олон төрлийн бүс, бүслүүр нь зэрлэг амьтан, ургамлын олон төрөл зүйлийн амьдрах орчныг бүрдүүлж байдаг. Эдгээр биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээ нь Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёлын болон хөгжлийн үндэс нь юм. Биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор Засгийн газраас нийт нутаг дэвсгэрийн 30 орчим хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад аваад байна. Гэвч уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн хэт ашиглалт нь тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдал болон экосистемд эрсдэл учруулсаар байна.

Орон нутгийн хүн амын нэлээд хэсэг нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд амьдардаг. Эдгээр газар нутаг эрсдэлд орсноор нутгийн иргэдийн амьжиргаанд ч мөн сөргөөр нөлөөлж байна. Хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшин доогуур, цаашлаад ядуурал нь тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН), тэдгээрийн орчны бүс дэх байгалийн баялгийг хэт ашиглах нэг шалтгаан болж байна. ТХГН-ийн удирдлагын тогтолцоо нь төсөв, санхүүгийн хүрэлцээ хангалтгүй байдгийн улмаас хүрээлэн буй орчны доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжгүй, мөн хамгаалалтын захиргаад нь мэргэжлийн ур чадвар, техникийн боломж, хүн хүчний хувьд ч дутагдалтай байна.

ЗОРИЛГО

Тусгай хамгаалалттай газар нутгийн тогтвортой хөгжлийг хангах суурь нөхцөл сайжирсан байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА БАРИЛ



Бодлогын зөвлөгөө өгөх (Үндэсний түвшинд)

ТХГН-ийн хууль эрх зүйн орчны талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд бодлогын зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлнэ. ТХГН-ийн хамгаалалтын захиргаад үйл ажиллагаагаа санхүүгийн хувьд илүү бие даан хэрэгжүүлж, олсон орлогоо өөрийн хамгаалалтын менежментэд эргүүлэн хөрөнгө оруулах боломж бүрдэх юм.



Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг хөгжүүлэх (Баруун бүс)

Төсөл нь төрийн захиргааны байгууллагууд болон оролцогч талуудын харилцан уялдаатай хамтын ажиллагаанд анхаарал хандуулж, тэдний чадавхыг үр дүнтэй ашиглах боломжоор ханган ажиллана. Төслийн өөр нэг зорилго нь өргөн уудам нутгийн байгалийн ландшафтыг хадгалан үлдээх, ховордсон амьтдын зүйлийн шилжих хөдөлгөөний замыг үр дүнтэй хамгаалахад оршино.

Захиалагч	ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)
Хамтран санхүүжүүлэгч	Европын Холбоо
Төсөл хэрэгжих бүс нутаг	Монгол Улс
Хамтран хэрэгжүүлэгч	Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Хэрэгжих хугацаа	2019-2024
Нийт санхүүжилт	10.830.000 EUR



Нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх (Баруун бүс)

Төслөөс ТХГН-ийн байгалийн баялгийн хэт ашиглалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор ТХГН, тэдгээрийн орчны бүсэд амьдардаг нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх боломжит хувилбаруудыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Эдгээр хувилбаруудын нэг нь тогтвортой, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг ТХГН-т хөгжүүлэх явдал юм. Аялал жуулчлалын чиглэлээр орон нутгийн болон үндэсний хэмжээний оролцогч талуудын хамтын ажиллагаа, харилцаа холбоог сайжруулахыг дэмжинэ.



Байгаль орчны мэдээлэл сурталчилгаа (Үндэсний түвшинд)

Төслөөс ТХГН-ийн байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны стратегийг боловсруулж, стратегийн сонгогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Нийгмийн сүлжээгээр олон нийтийг хамарсан сурталчилгаа, сургалтын сонирхолтой арга хэмжээнүүдийг зохион байгуулах замаар аялагчид, жуулчид болон нутгийн иргэд, мэргэжлийн хүмүүст мэдээллийг өргөн дэлгэр хүргэнэ.



Ойн тогтвортой менежмент (Хэнтий, Сэлэнгэ аймгууд)

Төслөөс ландшафтын шинэлэг менежментийг дэмжиж, эрэлтэд тулгуурласан ойн ашиглалтаас байгальд ээлтэй ойн ашиглалт руу шилжихэд дэмжлэг үзүүлнэ. Ойн тогтвортой менежмент нь орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжиж, улмаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох байдлыг нэмэгдүүлдэг.



Дүгнэлт...

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр төсөл нь биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах, нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн байгальд ээлтэй менежментийн урьдчилсан нөхцөлийг орон нутаг, бүс нутаг, түүнчлэн үндэсний хэмжээнд бүрдүүлэх юм.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ



Төслөөс ТХГН-ийн тухай хуулийг шинэчлэх, бусад хууль, дүрэм журмуудтай уялдуулан боловсруулах ажлыг чиглүүлэн ажиллаж байна. Шинэчилсэн хуулийн төслийг 2022/2023 онд УИХ-д өргөн барина.



Биологийн олон янз байдлыг тодорхойлох, хянах, иргэдийг мониторингийн ажилд татан оролцуулах зорилгоор гар утасны аппликейшн, вэбсайтыг хөгжүүлсэн. 1300 гаруй хэрэглэгчид бүртгүүлж 4500 гаруй ажиглалтаа илгээсэн.



Байгаль хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор хөгжлийн бусад түншүүдтэй хамтран Үндэсний Байгаль Хамгаалах Итгэлцлийн Сан байгуулахаар ажиллаж байна.



Төслөөс дэд бүтэц, тоног төхөөрөмжид санхүүгийн дэмжлэг үзүүлснээр 7 хамгаалалтын захиргаадын удирдлагын чадавх сайжрах боломж бүрдсэн.



Эдийн засгийн чадавхыг сайжруулах үйл ажиллагаанд төсөл хэрэгжиж буй сумдын нийт 460 гаруй төлөөлөл хамрагдсанаас 210 гаруй хүнд бизнес хөгжүүлэх талаар ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.



Төслийн санал боловсруулах сургалтад 100 гаруй орон нутгийн иргэдийг хамруулж эдгээрээс 23 жижиг хэмжээний төсөлд санхүүжилт олгосон. Эдгээр төслүүд нь амжилттай хэрэгжиж байна.



Хүнсний ногоо тариалах, зөгийн аж ахуй эрхлэх, цагаан идээ, арьс шир боловсруулах талаар сургалт зохион байгуулж нутгийн иргэдийн амьжиргааг дэмжсэн.



Сургалтын танхим, ажлын байр бүхий эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийг сумын түвшинд тохижуулав.



Аялал жуулчлалын хүрээнд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, орлого бий болгох, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (НИТАЖ), зочлох үйлчилгээ, сурталчилгаа, хог хаягдлын менежмент, аяллын маршрут боловсруулах, бэлэг дурсгалын зүйл зэрэг сэдвүүдээр 200 гаруй төлөөллийг сургалтад хамруулав.



Байгаль орчин, ТХГН-ийг хамгаалах зарчмыг баримтлан урт хугацаанд амьжиргааг дэмжих НИТАЖ-ыг Монгол Улсад хэрхэн амжилттай хэрэгжүүлэх талаар практикт суурилсан гарын авлагыг боловсруулан хэвлэн гаргав.



ТХГН-т зориулсан Байгаль орчны мэдээлэл, сургалт, сурталчилгаа (БОМСС)-ны стратегийг боловсруулж батлуулсан. "Ногоон Монголын төлөө" нөлөөллийн кампанит ажлыг вебсайт, фэйсбүүк групп, олон ангит кино, видео клип, комик ном болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, материалуудыг ашиглан үндэсний хэмжээнд зохион байгуулахаар санаачлав.




БОМСС-ын стратегийг хэрэгжүүлэх гарын авлагууд, ToolBoxes, анимэйшн видео, ТХГН-т аялагч, зочдод зориулсан танилцуулгуудыг боловсруулан гаргав.



Байгаль орчны боловсрол, харилцааны интерактив болон практикт чиглэсэн арга хэрэгсэл, ур чадварын талаар 100 гаруй оролцогчдыг сургалтад хамруулав.



Сэлэнгэ, Хэнтий аймгийн зургаан сумдад ойн тогтвортой менежментийн чадавхыг сайжруулах (мод тарих, арчилгааны огтлолт, ойн тооллого хийх) ажлууд хэрэгжиж эхэллээ. Энэхүү ажилд олон улсын ба дотоодын 12 их сургуулиудын нэгдсэн консорциум судалгааны дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.



Хэвлэлтийг:

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) GmbH
ХБНГУ-ын Бонн, Эшборн хотуудад оффистой

Холбоо барих:

Др. Михаэл Трокенбротд
"Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь" (SPACES) төсөл

Найман зовхис барилгын III давхар, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14251, Монгол улс
Т: +976 11 312282
М: +976 95000219
E: michael.trockenbrodt@giz.de
I: www.giz.de



Хамтран хэрэгжүүлэгч:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам



Захиалагч:

ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)

Дизайн/Зураг:

GIZ Монгол/SPACES төсөл

Он, сар:

2022 оны 10 дугаар сар

Агуулгыг Монгол дах GIZ хариуцна.